

**Эмийн бүртгэлийн журам батлах  
тухай.**

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Эмийн бүртгэлийн журам”-ыг 1 дүгээр, “Эмийн бүртгэлд эм, оношлуур бүртгүүлэх өргөдөл”-ийн маягтыг 2 дугаар, “Шинжээчийн ажиллах журам”-ыг 3 дугаар, “Бүртгэлийн гэрчилгээний загвар”-ыг 4 дүгээр, “Бүртгэлийн хураамж, түүнийг зарцуулах журам”-ыг 5 дугаар хавсралтаар, Эмийн бүртгэлийн шинжээчийн ашиг сонирхлын зөрлийн мэдүүлгийг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тухайн жилийн бүртгэлийн хураамжийн орлогыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын төсөвт зардалд “Төвлөрсөн арга хэмжээний зардлын зүйл”-ээр тусган батлуулж, эмийн бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхийг ЭМЯ-ны санхүү хөрөнгө оруулалтын газар /Н.Түмэндэмбэрэл/-т үүрэг болгосугай.
3. Бүртгэлийн хураамжийг зориулалтын дагуу зарцуулж, жил бүрийн эхний улиралд багтаан Хүний эмийн зөвлөлд тайлагнаж байхыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдлуулан оношлуурын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнийг тус газрын орон тооны дээд хязгаартаа багтаан Эмийн бүртгэл, баталгаажуулалтын **зохицуулалтын** хэлтсийн бүтцэд ажиллуулахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/-д даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар /Д.Жаргалсайхан/, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс /Ч.Мөнхдэлгэр/ нарт үүрэг болгосугай.
6. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны 38 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

## ЭМИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг зүйл.

1.1 Хүн амын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмийн түүхий эд болон оношлуур, оношлогооны урвалж (цаашид оношлуур гэх)-ийн өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай байдлыг хангах, “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-д нийцүүлэн Монгол улсын эмийн бүртгэл (цаашид “бүртгэл” гэх)-д бүртгэх, бүртгэлээс хасах, бүртгэлд өөрчлөлт оруулах харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.2 Хүний эмийн зөвлөл (цаашид “ХЭЗ” гэх)-өөс эм, оношлуурын бүртгэлийн асуудал болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, чанарын баталгаатай, эм үйлдвэрлэгчээс шууд нийлүүлж байгаа, Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээнд чухал шаардлагатай эмийг богино хугацаанд бүртгэлийг /цаашид түргэвчилсэн бүртгэл гэх/ хэлэлцэж шийдвэрлэнэ.

1.3 Дараах тохиолдолд түргэвчилсэн журмаар бүртгэх эм дараах тусгай шаардлага хангасан байна.

- Тухайн эм нь эмийн бүртгэлд ороогүй боловч үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, зонхилон тохиолдох өвчний эмчилгээ, оношлогооны удирдамжид орсон байх;
- АНУ-ын FDA, Австралийн TGA, Европын холбооны European Medicines Evaluation Agency, Их Британийн Medicines and Healthcare Products Regulatory Agency, Канадын ~~Health Products and Food Branch Health~~ байгууллага **Солонгос улсын Korean FDA** болон Япон улсын Нийгмийн хамгаалал, Хөдөлмөр, Эрүүл мэндийн яаманд бүртгэгдсэн байх;
- Яаралтай тусламж, Сэхээн амьдруулах тасагт хэрэглэх, өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаант өвчний эмчилгээ, оношлогооны стандартад орсон байх;

1.4 Улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийн зах зээлийн тандалт судалгаа (цаашид “тандалт судалгаа” гэх)-ны удирдамж, багийн бүрэлдэхүүн болон тухайн жилд эн тэргүүнд бүртгэх эмийн жагсаалтыг жил бүрийн нэгдүгээр улиралд ХЭЗ-ийн хурлаас баталж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрүүл мэндийн газар (ЗГХА-ЭМГ) хэрэгжилтийг хангаж ажиллана.

## **Хоёр.Эмийн бүртгэлийн бодлого, зарчим**

2.1 Бүртгэлийн бодлого, чиглэл, үйл ажиллагаанд эм, оношлуурын зах зээлийн болон идэвхи, чанар, аюулгүй байдлын тандалт судалгааны дүн, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, төрөлжсөн төв болон клиникийн эмнэлгийн эм зүйн албанаас ирүүлсэн захиалгыг ашиглана.

2.2 ХЭЗ эмийн бүртгэлийн асуудлаар шийдвэр гаргахдаа мэргэжлийн шинжээчийн дүгнэлт болон тухайн эмийн Монгол улс дахь хэрэгцээ, эмийн чанар, аюулгүй байдлын талаархи дараах мэдээллийг үндсэн шалгуур болгоно. Үүнд:

2.2.1 Монгол улсын эмчилгээ оношлогооны стандартад орсон болон Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон боловч урд нь эмийн бүртгэлд бүртгэгдээгүй болон 3 аас доош тоогоор бүртгэлтэй эсэх

2.2.2 Үйлдвэрлэгчээс шууд оруулж ирэх эсэх

2.2.3 Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн байдал болон хангамж, хүртээмжийн байдал

2.2.4 Тухайн худалдааны нэршлийн эмийг бүртгэсэн улс, тоо

2.2.5 Тухайн эм нийлмэл найрлагатай эсэх

2.2.6 Ерөнхий нэршлийн эм эсэх

2.2.7 Зарим улсын эмийн бүртгэлээс тухайн үндсэн үйлчлэгч бодисыг хэрэглэхийг хориглосон буюу тунгийн хязгаартай хэрэглэх шийдвэр гаргаж байсан эсэх

2.2.8 ДЭМБ-аас сэрэмжлүүлсэн эмийн жагсаалтад орсон эсэх

2.2.9 Үйлдвэрлэсэн улс болон тухайн эмийг бүртгэсэн улсын эрх бүхий байгууллагаас авсан мэдээлэл, мэргэжлийн шинжээчийн дүгнэлт

2.3 ХЭЗ-өөс шаардлагатай тохиолдолд зарим үйлдвэрлэгчтэй газар дээр нь танилцах багийг (шинжээч, мэргэжилтэн г.м) томилж болно.

## **Гурав. Бүртгэлд тавигдах шаардлага**

3.1 Улсын бүртгэлд бүртгүүлэх эм, оношлуур нь дараах шаардлага хангасан байна. Үүнд:

3.1.1 Эм үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн дүрэм” (GMP)-ийн, оношлуур үйлдвэрлэгч нь Европын болон АНУ-ын стандарт (CE, FDA, FDA-510 K)-ын шаардлага хангасан;

3.1.2 Экспортлогч улсын эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификаттай;

3.1.3 Эмийн идэвхи, найрлага, тун, тогтвортой байдал ба оношлуурын өвөрмөц, мэдрэг чанар нь шинжлэх ухааны туршилт судалгаагаар нарийвчлан тогтоогдсон;

3.1.4 Эмийн клиникийн өмнөх судалгаа, шинжилгээний дүн баталгаажсан;

3.1.5 Бүртгүүлэх эмийн үйлчлэл, чанар, аюулгүй байдал нь улсын бүртгэлтэй ижил төстэй эмийнхээс давуу болох нь шинжээчийн дүгнэлт, тандалт судалгааны дүнгээр баталгаажсан (түргэвчилсэн бүртгэлд хамаарахгүй);

3.1.6 Эмийн хэрэглэх, хориглох заалт, гаж нөлөө, эмийн харилцан үйлчлэл, тунгийн хязгаар нь эмнэлзүйн туршилтаар бүрэн нотлогдсон;

3.1.7 Бүртгэх эм оношлуурын сав баглаа боодол нь зураасан кодтой, хаяглалт шошго нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шаардлага хангасан монгол, англи, орос хэлний аль нэг дээр дагнасан байхаас гадна дээрхи хэл болон нэмэлт нэг улсын хэлтэй хосолсон байж болно;

3.1.8 Түргэвчилсэн бүртгэлд хамруулах эмийн сав баглаа боодлын хаяглалт, тэмдэглэгээ нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шаардлага хангасан, **наалт** хэлбэртэй байж болно. Наалтын нууцлалыг бүртгүүлэгч байгууллага хариуцна;

3.1.9 Импортын эм, оношлуур нь гурваас доошгүй улсад бүртгэгдсэн /уламжлалт эмэнд хамаарахгүй/;

3.1.10 Бүртгүүлэх импортын эм тухайн үйлдвэрлэсэн улсынхаа бүртгэлд бүртгэгдээд гурваас доошгүй жил болсон, экспортлогч улсад хэрэглэдэг байх;

### **Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа**

4.1 Тухайн эм, эмийн түүхий эд, оношлуурыг улсын бүртгэлд бүртгэх эсэх асуудлыг үйлдвэрлэгчээс баталгаажуулж ирүүлсэн баримт бичиг, үйлдвэрлэгчийн болон ЭМГ-тай гэрээ байгуулсан хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, мэргэжлийн шинжээчдийн болон шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн байгууллага, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ХЭЗ-ийн хурлаас шийдвэрлэнэ.

4.2 Эмийн бүртгэлийн материалыг хүлээн авах, ХЭЗ -ийн хуралд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг -Эрүүл мэндийн газар (ЭМГ) гүйцэтгэнэ.

4.3 ЭМГ-аас бүртгэлийн баримт бичгийг хүлээн авах, шинжээчид хуваарилах хуваарь, нэг удаагийн хурлаар хэлэлцүүлэх эмийн тоо хэмжээг тогтооно

4.4 Эмийг бүртгэх шийдвэрт олон улсын болон худалдааны нэршил, хэлбэр, тун, савлалтын хэмжээ, олгох нөхцөл, өвөрмөц ба мэдрэг чанар, бүртгэлийн хүчинтэй хугацаа, үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улсыг заана.

4.5 ХЭЗ-ийн хуралд хэлэлцүүлсэн эмийн тухайн шошго бүхий савлалтын хэлбэрийг улсын бүртгэлтэйд тооцох бөгөөд тус зөвлөлөөс өөрчлөлт оруулахыг зөвшөөрөөгүй өөр савлалттай эмийг бүртгэлд ороогүйд тооцно. (Энэ нь нийгмийн зах зээлээр түгээгдэж буй эмэнд хамаарахгүй )

4.6 Эм, эмийн түүхий эд, оношлуурыг 5, түргэвчилсэн журмаар бүртгэсэн эмийг 3 жилийн хугацаагаар бүртгэж гэрчилгээ олгоно.

4.7 Тандалт судалгаанд хамрагдсан эмийн шинжилгээнд Эрүүл мэндийн сайдын тушаалаар зөвшөөрсөн фармакопейг ашиглана.

4.8 Бүтээгдэхүүнээ бүртгүүлэхийг хүссэн эм үйлдвэрлэгч 2 дугаар хавсралтад заасан эм, оношлуур бүртгүүлэх өргөдлийг бөглөж, тухайн үйлдвэрийн эрх бүхий этгээд баталгаажуулсан холбогдох бичиг баримт албан хүсэлтийг электрон хувийн хамт нэгтгэн ЭМГ-т ирүүлнэ.

4.9 Эм үйлдвэрлэгч, тухайн үйлдвэрийг Монголд төлөөлөх эрхтэй төлөөлөгчийн газар, тухайн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх гэрээтэй эм ханган нийлүүлэх байгууллагын аль нэг нь ЭМГ-аас гаргасан зааврын дагуу Эмийн бүртгэлийн материалыг хадгаламжийн нэгж болгон хүлээлгэж өгнө.

4.10 Бүртгэх эм, эмийн түүхий эд, оношлуурын бүртгэлийн материалаас монгол хэлээр орчуулах шаардлагатай бичиг баримт болох эм, оношлуурын хэрэглэх зааврыг бүртгүүлэгч байгууллага мэргэжлийн өндөр төвшинд орчуулж ирүүлнэ.

4.11 ЗГХА-Эрүүл мэндийн газар /цаашид ЭМГ гэх/-аас орчуулгыг мэргэжлийн түвшинд хянах ажлыг зохион байгуулж хэрэглэгчдэд зориулсан хэрэглэх зааврын бүтэц агуулгыг нэг загварт оруулан ХЭЗ-ийн тэмдэгээр баталгаажуулна.

4.12 ЭМГ шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэгчээс ирүүлсэн бичиг баримтын талаар тухайн улсын эрх бүхий байгууллагаас тодруулга авна.

4.13 Эмийн бүртгэлийн бичиг баримт хүлээн авахдаа үйлдвэрлэгчээс баталгаажуулсан өргөдлийг хүчинтэй гэж үзэх бөгөөд факс, цахилгаан шуудангаар илгээсэн, тамга тэмдэггүй бичиг баримтыг шаардлага хангахгүйд тооцно. Ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг бүртгүүлэгч байгууллага хариуцна.

4.14 ХЭЗ-өөс эмнэлзүйн туршилт хийх шийдвэр гаргасан тохиолдолд туршилт хийх эмнэлэг, туршилтанд хамруулах хүний тоог нарийн тогтооно. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 21-дүгээр зүйлийн дагуу эмнэлзүйн туршилтыг явуулж ХЭЗ-ийн хурлаар дахин хэлэлцүүлнэ.

4.15 Эм ханган нийлүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй зөвхөн нэг аж ахуйн нэгж нэр заасан бүтээгдэхүүнийг Монгол улсад бүртгүүлэхээр үйлдвэрлэгчтэй гэрээ байгуулсан байна. Бүртгүүлэх гэрээнд дараах заалтыг зайлшгүй оруулсан байна. Үүнд:

- а. Бүртгэлийн бичиг баримтын үнэн байдлыг өргөдөл гаргагч хариуцах
- б. Хадгаламжийн нэгж үүсгэх үйл ажиллагааны талаар
- в. Эмнэлгийн мэргэжилтэн болон өвчтөнд зориулсан эм хэрэглэх зааврыг орчуулах үйл ажиллагааны талаар
- г. Бүртгэх эмийн шинжилгээний хураамж, тандалт судалгааны явцад хөндлөнгийн лабораториор шинжлүүлэх зардлыг үйлдвэрлэгч, төлөөлөгчийн газар, эм ханган нийлүүлэх байгууллагын аль нь хариуцах талаар
- д. Эмийн бүртгэлийн хураамжийг нэхэмжилсэн хугацаанд барагдуулах, шинжээчийн дүн шинжилгээ эхэлсэнээс хойш бүртгүүлэх хүсэлтийг буцаахгүй байх талаар

е. Бүртгэлийн хүчинтэй хугацаа бүхий гэрчилгээг үйлдвэрлэгч хүлээн аваагүй тохиолдолд Монгол улсад хэрэглэх, борлуулахаар гэрээ байгуулахыг хориглох талаар

ё. ХЭЗ-өөс бүртгэлээс хасч зах зээлээс эргүүлэн татах шийдвэр гарсан эмийг зах зээлээс эргүүлэн татах зардлыг бүртгүүлсэн үйлдвэрлэгч хариуцах талаар

ж. Гэрээний хүчинтэй хугацаа, өөрчлөлтийн талаар

з. Савлалт хаяглалт, шошгын нууцлалыг хариуцах талаар

и. Тухайн эмийг хэрэглэх явцад хүний эрүүл мэнд, амь нас, эдийн засгийг хохироосон нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон бол үүссэн хохирлыг барагдуулах хариуцлагын талаар

и. Эмийн бүртгэлийн талаархи ХЭЗ-ийн хурлын шийдвэрийг гадаадын үйлдвэрлэгчид хүргүүлэх шийдвэрийг эм ханган нийлүүлэх байгууллага хүлээх талаар

4.16 Бүртгэлийн үйл ажиллагаа дараах үе шаттай, дурьдсан хугацаанд хэрэгжинэ.

Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
Бүртгэлийн материалд анхдагч дүн шинжилгээ хийх	Материал хүлээж авснаас хойш 14 хоног	ЭМГ
Эмийн бүртгэлийн хураамж нэхэмжлэх, төлбөр барагдуулах	Анхдагч дүн шинжилгээ хийснээс хойш 1 сарын дотор	Бүртгүүлэгч байгууллага
Эм зүй, эмнэлзүйн шинжээчдийн дүгнэлт гаргах	Тус бүр 1 сарын дотор	ЭМГ, шинжээчид
Хүний эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Шинжээчийн дүгнэлт гарснаас хойш 1 сарын дотор	ЭМГ
Хурлын шийдвэрийг хүргүүлэх	Хурлын тэмдэглэл эцэслэн гарснаас хойш ажлын 10 хоногт	ЭМГ, Эм бүртгүүлэгч
ХЭЗ-ийн хурлаас түдгэлзүүлж хойшлуулсан тохиолдолд эмийн бүртгэлийг дахин хэлэлцүүлэх.	2 сарын дотор	ХЭЗ, Эм бүртгүүлэгч
Эмийн улсын бүртгэлийн гэрчилгээ бичиж олгох	ХЭЗ-ийн хурлын тэмдэглэл эцэслэн гарсанаас хойш ажлын 10 хоногт	ЭМГ
Эмийн бүртгэлийг "Licemed" програмд оруулах	Гэрчилгээ хүлээлгэн өгснөөс хойш ажлын 5 хоногт	ЭМГ

4.17 Бүртгэлийн гэрчилгээг нэг хувь үйлдэж бүртгүүлэгч эм ханган нийлүүлэх байгууллагад олгох ба хуулбарыг нь батлагдсан хэрэглэх зааврын /эмнэлгийн мэргэжилтэн болон өвчтөнд зориулсан/ хамт ЭМГ-т архивлана.

4.18 Бүртгэлийн гэрчилгээг ХЭЗ-ийн даргын гарын үсэг, ЭМЯ-ны тэмдгээр баталгаажуулна.

### Тав. Бүртгэлийн дугаар

5.1 Эмийн бүртгэлийн дугаар нь тухайн эмийн гарал үүсэл, бүртгэгдсэн он, бүртгэлийн хүчинтэй хугацаа (он сараар), эмийн ангилалын код (АТС), эмийг олгох хэлбэр, хувийн дугаарыг агуулна.

5.2 Эмийн бүртгэлд бүртгэгдсэн эмийг дараах загвараар дугаарлана.  
F-93-1098-A-D-99999

5.3 Эмийн бүртгэлийг дугаарлахад нэр томъёоны дараах товчлолыг ашиглана.  
Үүнд:

	Товчлол	Тайлбар
Эх үүсвэр	<b>F</b> <b>L</b> <b>R</b>	Foreign=гадаад буюу импортын эм; Local=Эх орны үйлдвэрийн Rapid=Түргэвчилсэн бүртгэл
Монголд анх бүртгэгдсэн он	<b>00</b>	Жишээлбэл: 93= 1993, 97= 1997, г.м сүүлийн 2 цифр байх
Гэрчилгээний хүчинтэй хугацаа байх	<b>0000</b>	Жишээлбэл: 1098=1998 оны 10 сард
<b>АТС код</b>	<b>A</b>	Alimentary tract and metabolism - хоол боловсруулах замын эмгэгт хэрэглэх эм
	<b>B</b>	Blood and blood forming organs - Цус, цус төлжүүлэх эрхтний эмгэгт хэрэглэх эм
	<b>C</b>	Cardiovascular system - зүрх судасны тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	<b>D</b>	Dermatologicals - арьсны эмгэгт хэрэглэх эм
	<b>G</b>	Genito urinary system and sex hormones - шээс, бэлгийн тогтолцоо болон бэлгийн даавар
	<b>H</b>	Systemic hormonal preparations, excl. sex hormones and insulins - бэлгийн даавар, инсулинаас бусад тогтолцооны дааврын

		бэлдмэл
	<b>J</b>	General antiifective for systemic use - нянгийн эсрэг хэрэглэх эм
	<b>L</b>	Antineoplastic and immunomodulating agents - хавдрын эсрэг болон дархлаа нөлөөт бодис
	<b>M</b>	Musculo- skeletal system - булчин - тулгуур эрхтэний тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	<b>N</b>	Central nervous system - төв мэдрэлийн тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	<b>P</b>	Antiparasitic products, insecticides and repellents - паразит , шавьжийн эсрэг бэлдмэл
	<b>R</b>	Respiratory system - амьсгалын тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	<b>S</b>	Sensory organs - мэдрэхүй эрхтний эмгэгт хэрэглэх эм
	<b>T</b>	Taditional medicine-уламжлалт эм
	<b>V</b>	Бусад, төрөл бүрийн бэлдмэл
Олгох нөхцөл	<b>P</b> <b>O</b> <b>D</b> <b>H</b>	Prescription only=жороор, OTC=жоргүй Dangerous = мансууруулах Hospital=Эмчийн тусгай хяналтад, эмнэлгийн нөхцөлд
Тухайн эмийн дугаар	<b>00000</b>	00050; 00051; г.м 5 цифрээр

5.4 Оношлуурын бүртгэлийн дугаар нь тухайн оношлуурын гарал үүсэл, бүртгэгдсэн он, бүртгэлийн хүчинтэй хугацаа (он сараар), шинжилгээний төрөлд суурилсан ангилал, оношлуур, урвалжийн арга, хэлбэр, онцлог, хувийн дугаарыг агуулна.

5.5 Улсын бүртгэлд бүртгэгдсэн оношлуурыг дараах загвараар дугаарлана.  
F-07-0810-Im-E-hiv-00020



5.6 Оношлуурын бүртгэлийг дугаарлахад нэр томъёоны дараах товчлолыг ашиглана. Үүнд:

	<b>Товчлол</b>	<b>Тайлбар</b>
Эх үүсвэр	<b>F</b> <b>L</b>	Foreign = гадаад буюу импортын оношлуур, урвалж Local= эх орны үйлдвэрийн оношлуур, урвалж
Монголд анх бүртгэгдсэн он	<b>00</b>	Жишээлбэл: 07=2007, 08=2008 г.м сүүлийн 2 цифр байх
Гэрчилгээний хүчинтэй хугацаа	<b>0000</b>	Жишээлбэл: 0810=2010 оны 08 сар хүртэл хүчинтэй
Шинжилгээний төрөлд суурилсан ангилал	<b>Bi</b> <b>Cc</b> <b>He</b> <b>Im</b> <b>Ih</b> <b>Mb</b> <b>Mi</b> <b>Pt</b> <b>O</b>	<b>Bi</b> -Biochemistry- Биохими <b>Cc</b> - Clinical chemistry – Клиникийн хими <b>He</b> - Hematology – Гематологи <b>Im</b> - Immunology – Иммунологи <b>Ih</b> - Immunohematology – Иммуногематологи <b>Mb</b> - Molecular biology – Молекулбиологи <b>Mi</b> - Microbiology – Микробиологи <b>Pt</b> - Pathology – Патологи <b>O</b> - Other - Бусад
Оношлуурын арга	<b>E</b> <b>R</b>	Жишээлбэл: E- ELISA буюу ФХЭБУ аргын, R-түргэвчилсэн аргын оношлуур г.м
Урвалжийн хэлбэр	<b>D</b> <b>L</b>	D- хуурай L- шингэн г.м
Оношлуур, урвалжийн онцлог	<b>Hiv</b> <b>hel</b>	Жишээлбэл: hel –хелико бактер оношлох
Тухайн оношлуурын урвалжийн дугаар	<b>00000</b>	00010;00011; г.м 5 цифрээр

### **Зургаа. Бүртгэлийг өөрчлөх, сунгах, хүчингүй болгох**

1. ЭМГ-аас бүртгэлийн материалд орох өөрчлөлтийг ХЭЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
2. Эм, эмийн түүхий эд, оношлуурын бүртгэлд өөрчлөлт оруулахад дараах бичиг баримт бүрдүүлнэ.

- i. Эмийн бүртгэлд өөрчлөлт оруулах тухай үйлдвэрлэгчийн хүсэлт
- ii. Улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /эх хувь/
- iii. Өөрчлөлтийн дэлгэрэнгүй тайлбар, холбогдох материал, загвар дээж

3. Эм, эмийн түүхий эд оношлуурын бүртгэлийн хугацааг сунгуулахад дараах бичиг баримт бүрдүүлнэ. Үүнд:

- улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /эх хувь/
- эрх бүхий хяналтын байгууллагаас үйлдвэрлэгч нь ДЭМБ-ын жишигт нийцэхүйц эм үйлдвэрлэлийн дүрэм (GMP)-ийн шаардлагад нийцсэнийг нотлох бичиг баримт /үйлдвэрлэгчийн тэмдгээр баталгаажуулсан/,
- эмийн бүтээгдэхүүний сертификат /эх хувь/
- савлалт хаяглалт, шошгын загвар /тэмдгээр баталгаажуулсан байх/
- эмнэлгийн мэргэжилтэн болон өвчтөнд зориулсан хэрэглэх заавар, монгол хэлээр (Өөрчлөлт орсон бол баталгаажуулна.)
- хугацаа дууссан бүртгэлийн гэрчилгээний хуулбар

4. Дараах тохиолдолд **бүртгэхгүй** буюу бүртгэлийг хүчингүй болгох асуудлыг ХЭЗ-өөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

- Эмийн чанар эргэлзээтэй, лабораторид давтан шинжилгээнд хамрагдаж, шаардлага хангаагүй үйлдвэрлэгчийн эм;
- Бүртгэсэн эм, оношлуурыг хэрэглэх явцад илэрхий гаж нөлөө илэрсний улмаас хүн нас барсан, удаан хугацаагаар эмчлүүлсэн, тахир дутуу болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан нь нотлогдсон;
- **Үйлдвэрлэлийн технологи орчин үеийн шаардлага хангахгүй болохыг эм зүйн шинжээч нотолсон;**
- Үйлдвэрлэгчээс ирүүлсэн эмийн савлалт, хаяглалт нь нууцлал багатай, эм ханган нийлүүлэх байгууллагууд өөр савлалтын хэлбэртэй импортлосон болох нь мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтаар тогтоогдсон, дуурайлган хийх боломжтой, найдваргүй болох нь батлагдсан;
- Тухайн эмийн талаар эмнэлгийн байгууллага, иргэдээс ирсэн гомдлыг хяналтын байгууллагын шийдвэрлэсний дагуу бүртгэлээс хасах санал ирүүлсэн;
- Бүртгүүлэгч тал бүртгэлийн хүчинтэй хугацаанд сунгуулах хүсэлтээ ирүүлээгүй;
- Бүртгүүлснээс хойш 1 жилийн хугацаанд зах зээлд нийлүүлээгүй;
- Хоёр буюу түүнээс дээш эх орны үйлдвэрт үйлдвэрлэдэг эмийн бүтээгдэхүүний эмчилгээний үйлдлийн идэвх, чанар, аюулгүй байдал импортын бүтээгдэхүүнийг орлох эсэхийг тандалт судалгаагаар тогтоон ХЭЗ-өөс эх орны бүтээгдэхүүнээс давуугүй гэж тогтоосон импортын эм;
- Улсын бүртгэлд 10-аас илүү хувилбараар бүртгэсэн ижил эмийн хэлбэрүүдийг тандалт судалгаанд хамруулсан дүнг үндэслэн эмчилгээний үйлдлийн идэвх, чанар, аюулгүй байдлаар бусдаас давуу болох нь тогтоогдоогүй импортын эм;

6.7 Бүртгэлээс хассан эмийг ажлын 5 хоногийн дотор мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлж мэдээний санд өөрчлөлт оруулна.

6.8 ЭМГ тухайн бүтээгдэхүүнийг зах зээлээс эргүүлэн татах шийдвэрийг ХЭЗ-ийн шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлж ажиллана.

**Долоо. Эмийн бүртгэлийн баримт бичгийг  
хадгалах, ашиглах**

7.1 ЭМГ-аас эмийн бүртгэлийн бичиг баримтын хадгаламжийн нэгж үүсгэн (цаасан болон электрон), баяжилтыг тогтмол хийнэ.

7.2 Бүртгэхээр шийдвэрлэсэн эмийн бичиг баримтыг ажлын 15 хоногт багтаан хувийн дугаар олгож архивын зориулалтын тавиур шүүгээ бүхий шаардлага хангасан өрөөнд эмх цэгцтэй байршуулна.

7.3 Бүртгэсэн эмийн мэдээний сан, бүртгэл нь хүчин төгөлдөр эмийн баримт бичгийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг ЭМГ хариуцаж, Архивын хуулийн дагуу хадгална.

7.4 Бүртгэлийн бичиг баримтыг зөвхөн албан хэрэгцээнд ЭМГ-ын “Архивын баримт ашиглах, лавлагаа хуулбар олгох” журмын дагуу ашиглана.

--xxx--

**A. УЛСЫН БҮРТГЭЛД ИМПОРТЫН ЭМ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**  
**MEDICINES REGISTRATION APPLICATION FORM FOR IMPORT PRODUCT**

**Өргөдлийн хэлбэр** (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)  
*Type of application (check the box applicabel)*

- Шинээр бүртгүүлэх  
*New registration for a pharmaceutical product*
- Бүртгэлд өөрчлөлт оруулах  
*Variation to an existing marketing authorization*
- Хугацаа сунгуулах  
*Renewal of registration*

Өргөдлийн 1-хэсгээс бусдыг Англи хэл дээр зөвхөн эм үйлдвэрлэгч бөглөнө. (*Fill in the application by only manufacturer in English except Part-I*)

<b>IXЭСЭГ.</b> <b>PART I</b>	<b>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.</b>  Өргөдөл гаргагч нь тухайн үйлдвэрийг Монголд төлөөлөх эрхтэй төлөөлөгчийн газар эсвэл эмийн үйлдвэртэй тухайн эмийг бүртгүүлэх гэрээ байгуулсан Монгол улсын эм ханган нийлүүлэх байгууллага байна.  <i>APPLICANT INFORMATION</i>  <i>The applicant should be represent a foreign manufacturer in Mongolia or only one Mongolian drug procurement organization with contract between manufacturer on registration for listed medicine(s)</i>
Байгууллагын нэр <i>Name of organization</i>	
Ажлын хаяг <i>Business address</i>	
Шуудангийн хаяг <i>Postal address</i>	
Утасны дугаар <i>Telephone number</i>	
Факсын дугаар <i>Fax number</i>	

Е-мэйл хаяг <i>E-mail address</i>	
Харилцах хүн <i>Contact person</i>	
<b>II ХЭСЭГ.</b> <b><i>PART II</i></b>	<b>ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> <b><i>MANUFACTURER INFORMATION</i></b>
Нэр <i>Name</i>	
Шуудангийн хаяг <i>Postal address</i>	
Утасны дугаар <i>Telephone number</i>	
Факсын дугаар <i>Fax number</i>	
Вэб хаяг <i>Web page</i>	
Харилцах хүн <i>Contact person</i>	
Е-мэйл хаяг <i>E-mail address</i>	
<b>III ХЭСЭГ.</b> <b><i>PART III</i></b>	<b>БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> <b><i>PRODUCT INFORMATION</i></b>
Эмийн худалдааны нэршил <i>Proprietary name (trade name)</i>	
Эмийн ерөнхий нэршил	

(хэрвээ байгаа бол олон улсын) <i>Approved generic name(s)</i> <i>(use the INN, if any)</i>			
Үйлчлэгч бодисын нэр, тун хэмжээ <i>Name and strength of active ingredients</i>			
<i>Нэр</i> <i>Name</i>	<i>Тун хэмжээ</i> <i>Strength</i>	<i>Нэр</i> <i>Name</i>	<i>Тун хэмжээ</i> <i>Strength</i>
1.		4.	
2.		5.	
3.		6.	
Туслах бодисын нэр тун хэмжээ <i>Name and strength of inactive ingredients</i>			
<i>Нэр</i> <i>Name</i>	<i>Тун хэмжээ</i> <i>Strength</i>	<i>Нэр</i> <i>Name</i>	<i>Тун хэмжээ</i> <i>Strength</i>
1.		5.	
2.		6.	
3.		7.	
4.		8.	
<i>Эмийн хэлбэр</i> <i>Dosage form</i>			
<i>Хадгалах нөхцөл</i> <i>Storage condition</i>			
<i>Хүчинтэй хугацаа</i> <i>Shelf life</i>			
<i>Савлалтын хэлбэр</i>			

<i>Primary packaging</i>				
Савлалтын хэмжээ (нэгж ба бөөнөөр савласан) <i>Packing size(unit and bulk package)</i>				
Олгох нөхцөл /жороор, жоргүй г.м/ <i>Dispensing category /prescription or OTC etc/</i>				
Хэрэглэх арга зам <i>Route of administration</i>				
Хүний биеийн бүтэц эмчилгээнд суурилсан ангилал <i>Anatomical therapeutic classification</i>				
Фармакологийн ангилал <i>Pharmacological classification</i>				
Гадаад байдал <i>Description</i>	<b>Өнгө/Color</b>	<b>Хэлбэр/Form</b>	<b>Хэмжээ/Size</b>	<b>бүрхүүл/Coating</b>
	<b>Бусад/Other description</b>			
Хэрэглэх заалт <i>Indications</i>				
Хориглох заалт <i>Contraindications</i>				
Мэдээлэгдсэн гаж нөлөө <i>List of reported side effects</i>				

Экспортын үнэ <i>Price for export</i>	
<b>IV ХЭСЭГ.</b> <b><i>PART IV</i></b>	<b>БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> <b><i>REGISTRATION INFORMATION</i></b>
Үйлдвэрлэсэн улсын нэр <i>Country of origin</i>	
Үйлдвэрлэгч улсад бүртгэсэн дугаар <i>Registration number in country of origin</i>	
Анх бүртгэгдсэн он сар өдөр <i>Date of registration in first</i>	<i>(dd/mm/yy)</i>
Тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн улсын тоо, нэр <i>Number and name of countries, this product was registered</i>	

..... (нэр) миний Монгол улсын эмийн бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн бүх баримт бичиг, өргөдөл нь үнэн бөгөөд эх хувь байна.

.....Гарын үсэг .....он .....сар .....өдөр

I ..... declare that the particulars given in this application are true and correct, and that all accompanying reports and documents supplied for the registration of medicinal products in MONGOLIA are true and are authentic copies.

Date..... Authorized signature.....

Хаяг:  
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
Эрүүл мэндийн газар  
Сүхбаатар дүүрэг, Энхтайван 13 б  
Улаанбаатар 210648, Монгол улс  
Факс: 976-11-320633

Address:  
The implementing agency of the  
government of Mongolia  
Department of Health  
Sukhbaatar district, Enkhtaivan str 13b  
Ulaanbaatar 210648, Mongolia  
Fax: 976-11-320633



**ИМПОРТЫН ЭМИЙН БҮРТГЭЛД ШААРДЛАГАТАЙ МАТЕРИАЛУУД**  
**REQUIRED MATERIALS FOR MEDICINES REGISTRATION FOR IMPORT**

1. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх хүсэлт  
**The original official letter for registration in state registry of medicine of Mongolia approved by authorized person of manufacturer**
2. Монгол улсын эм ханган нийлүүлэх байгууллага эсхүл төлөөлөгчийн газрын үйлдвэртэй эмийн бүртгэлийн талаар байгуулсан гэрээний хувь  
**Copy of the contract between Mongolian wholesaler and representative or manufacturer**
3. Холбогдох эрх бүхий хяналтын байгууллагаас үйлдвэрлэгч нь ДЭМБ-ын жишигт нийцэхүйц эм үйлдвэрлэлийн дүрэм (GMP)-ийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;  
**Document from relevant drug regulatory authority certifying that the manufacturer is in compliance of the GMP requirements of the country**
4. Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь (ДЭМБ-ын жишгийн дагуу );  
**The Original pharmaceutical product certificate (CoPP) for Mongolia, WHO- type are attached (for WHO Certification Scheme).**
5. Бусад улсад бүртгэсэн байдал /гадаадын 3 улсад бүртгэсэн гэрчилгээний хуулбарыг үйлдвэрлэгчийн тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх/;  
**Registration status in other countries, copy of registration certificate in 3 countries /with stamp of manufacturer/**
6. Үйлдвэрийн танилцуулга /CD-ээр үйлдвэрлэлийн процессыг харуулсан медиа хэлбэрээр, цаасаар 1-2 хуудсанд багтаан монгол хэлээр орчуулж ирүүлэх/;  
**Profile of the manufacturer /soft copy shown manufacturing process and hard copy translated in Mongolian briefly/**
7. Бүтээгдэхүүний тодорхойлолт, хэрэглэх заалтууд, бусад эм болон эмийн хэлбэртэй харилцан нөлөөлөх нөлөөлөл, гаж нөлөө;  
**Product specifications, summary of main indications, brief summary of the main interaction with other medicaments and other forms of interaction, brief summary of the main adverse side effects**
8. Эцсийн бүтээгдэхүүний шинжилгээний сертификатын эх хувь /үйлдвэрлэгчийн болон ЭМГ-тай гэрээтэй лабораторийн дүн/, аргачлал;  
**Original certificate /manufacturer's and contracted laboratory's/ and method of analysis of the finished product**
9. Үндсэн үйлчлэгч болон туслах бодисын гарал үүсэл, шинжилгээний сертификат,  
**Source and Certificate of active and inactive ingredient(s)**
10. Бүтээгдэхүүний хадгалах хугацааг баталсан тогтвортой чанарын судалгааны дүн;

### ***Stability study data justifying the shelf life of the medicinal product***

11. Бүтэн цувралыг хамруулсан үйлдвэрлэлийн ажиллагааны заавар, үйлдвэрлэлийн процесс, схем (дамжлага дундын хяналтыг оруулах);  
***Master manufacturing formula of including details of batch size, manufacturing process (including in-process quality control)***
12. Биошингэцийн судалгаа;  
***Bioavailability studies***
13. Эмийн хорон чанар (Ерөнхий нэршлийн эмэнд хамаарахгүй), идэвхи, аюулгүй байдлыг судалсан судалгааны дүгнэлт  
***Summary clinical data on the toxicity (Not relevant to generic drug) the safety and efficacy of the product***
14. Эмнэлгийн мэргэжилтэн болон өвчтөнд зориулсан хэрэглэх заавар (тэмдгээр баталгаажуулсан байх)  
***Instruction of medicine for medical professions and package insert leaflet.***
15. Эмийн анхдагч болон хоёрдогч савлалтын загвар зураг, шошго, хаяглалт, хайрцаг г.м  
***Primary and secondary packaging design such as label, pamphlet, carton.***
16. Эмийн загвар дээж  
***Sample of medicine***

### **ТҮРГЭВЧИЛСЭН ЖУРМААР БҮРТГЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ REQUIRED MATERIALS FOR RAPID MEDICINES REGISTRATION**

1. Улсын бүртгэлд эм бүртгүүлэх өргөдөл
2. Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь (ДЭМБ-ын жишгийн дагуу);
3. АНУ-ын FDA, Австралийн TGA, Европын холбооны European Medicines Evaluation Agency, Их Британийн Medicines and Healthcare Products Regulatory Agency, Канадын Health Products and Food Branch Health байгууллага болон Япон улсын Нийгмийн хамгаалал, Хөдөлмөр, Эрүүл мэндийн яамны аль нэгэнд бүртгэгдснийг нотлох гэрчилгээний баталгаажсан хуулбар
4. Эмнэлгийн мэргэжилтэнд болон өвчтөнд зориулсан хэрэглэх заавар
5. Эцсийн бүтээгдэхүүний шинжилгээний аргачилал, сертификат /үйлдвэрлэгчийн болон гэрээт лабораторийн/
6. Савлалт, хаяглалт, шошгын загвар
7. Эмийн загвар дээж

## Б. УЛСЫН БҮРТГЭЛД ДОТООДЫН ҮЙЛДВЭРИЙН ЭМ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)

- Шинээр бүртгүүлэх
- Бүртгэлд өөрчлөлт оруулах
- Хугацаа сунгуулах

I ХЭСЭГ.	ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ
Нэр	
Шуудангийн хаяг	
Утасны дугаар	
Факсын дугаар	
Вэб хаяг	
Харилцах хүн	
E-мэйл хаяг	
II ХЭСЭГ.	БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ
Эмийн худалдааны нэршил	

Эмийн ерөнхий нэр (хэрвээ байгаа бол олон улсын нэр)			
Үйлчлэгч бодисын нэр, тун хэмжээ			
<i>Нэр</i>	<i>Тун хэмжээ</i>	<i>Нэр</i>	<i>Тун хэмжээ</i>
1.		4.	
2.		5.	
3.		6.	
Туслах бодисын нэр тун хэмжээ			
<i>Нэр</i>	<i>Тун хэмжээ</i>	<i>Нэр</i>	<i>Тун хэмжээ</i>
1.		5.	
2.		6.	
3.		7.	
4.		8.	
Эмийн хэлбэр			

Хадгалах нөхцөл				
Хүчинтэй хугацаа				
Савлалтын хэлбэр				
Савлалтын хэмжээ (нэгж ба бөөнөөр савласан)				
Олгох нөхцөл /жороор, жоргүй г.м/				
Хэрэглэх арга зам				
Хүний биеийн бүтэц эмчилгээнд суурилсан ангилал				
Фармакологийн ангилал				
Гадаад байдал	<b>Өнгө</b>	<b>Хэлбэр</b>	<b>Хэмжээ</b>	<b>бүрхүүл</b>
	<b>Бусад</b>			
Хэрэглэх заалт				
Хориглох заалт				

Мэдээлэгдсэн гаж нөлөө	
Бөөний үнэ	
<b>III ХЭСЭГ.</b>	<b>БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>
Эмийн үндсэн үйлчлэгч бодисын үйлдвэрлэгчийн нэр, хаяг	
Эмийн үндсэн үйлчлэгч бодисыг Монгол улсад бүртгэсэн дугаар, хүчинтэй хугацаа	

..... (нэр) миний Монгол улсын эмийн бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн бүх баримт бичиг, өргөдөл нь үнэн бөгөөд эх хувь байна.

.....Гарын үсэг .....он .....сар .....өдөр

Хаяг:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

Эрүүл мэндийн газар

Сүхбаатар дүүрэг, Энхтайван 13 б

Улаанбаатар 210648, Монгол улс

Факс: 976-11-320633

### **ДОТООДЫН ҮЙЛДВЭРИЙН ЭМИЙН БҮРТГЭЛД ШААРДЛАГАТАЙ МАТЕРИАЛ**

1. Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан оюуны өмчийн гэрчилгээний хуулбар /хэрэв байвал/;
2. Үйлдвэрийн танилцуулга /цаасан болон электрон хэлбэрээр/;
3. Бүтээгдэхүүний тодорхойлолт, хэрэглэх заалтууд, бусад эм болон эмийн хэлбэртэй харилцан нөлөөлөх нөлөөлөл, гаж нөлөө;
4. Тухайн эмийн бүтээгдэхүүний Монгол улсын стандарт /хугацаа хүчинтэй, эх хувь байх /
5. Эцсийн бүтээгдэхүүний шинжилгээний сертификат /Үйлдвэрлэгчийн болон ЭМГ-тай гэрээтэй хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн байна/;
6. Үндсэн үйлчлэгч болон туслах бодисын гарал үүсэл, шинжилгээний сертификат,

7. Бүтээгдэхүүний хадгалах хугацааг баталсан тогтвортой чанарын судалгааны дүн;
8. Бүтэн цувралыг хамруулсан үйлдвэрлэлийн ажиллагааны заавар, үйлдвэрлэлийн процесс, схем (дамжлага дундын хяналтыг оруулах);
9. Эмийн хорон чанар /ерөнхий нэршлийн эмэнд хамаарахгүй/, идэвх, аюулгүй байдлыг судалсан судалгааны материал;
10. Эмнэлгийн мэргэжилтэн болон өвчтөнд зориулсан хэрэглэх заавар (тэмдгээр баталгаажуулсан байх)
11. Эмийн анхдагч болон хоёрдогч савлалтын загвар зураг, шошго, хаяглалт, хайрцаг г.м
12. Эмийн загвар дээж

**В. УЛСЫН БҮРТГЭЛД УЛАМЖЛАЛТ  
ЭМ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ  
MEDICINES REGISTRATION APPLICATION FORM  
FOR TRADITIONAL MEDICINES**

**Өргөдлийн хэлбэр** (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)  
*Type of application (check the box applicabel)*

- Шинээр бүртгүүлэх  
*New registration for a pharmaceutical product*
- Бүртгэлд өөрчлөлт оруулах  
*Variation to an existing marketing authorization*
- Хугацаа сунгуулах  
*Renewal of registration*

Өргөдлийн 1-хэсгээс бусдыг Монгол эсвэл Англи хэл дээр зөвхөн эм үйлдвэрлэгч бөглөнө. *(Fill in the application by only manufacturer in Mongolian or in English except Part-I)*

*Эх орны болон импортын эмийн аль алинд хамаарна. (This form belongs to both of import and local product)*

<b>IXЭСЭГ.</b>  <b>PART I</b>	<p><b>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.</b></p> <p>Өргөдөл гаргагч нь тухайн үйлдвэрийг Монголд төлөөлөх эрхтэй төлөөлөгчийн газар эсвэл эмийн үйлдвэртэй тухайн эмийг бүртгүүлэх гэрээ байгуулсан Монгол улсын эм ханган нийлүүлэх байгууллага байна.</p> <p><i>APPLICANT INFORMATION</i></p> <p><i>The applicant should be represent a foreign manufacturer in Mongolia or only one Mongolian drug procurement organization with contract between manufacturer on registration for listed medicine(s)</i></p>
Байгууллагын нэр <i>Name of organization</i>	
Ажлын хаяг <i>Business address</i>	
Шуудангийн хаяг <i>Postal address</i>	
Утасны дугаар <i>Telephone number</i>	



Факсын дугаар <i>Fax number</i>	
Вэб хаяг <i>Web page</i>	
Харилцах хүн <i>Contact person</i>	
Е-мэйл хаяг <i>E-mail address</i>	
<b>II ХЭСЭГ.</b> <b><i>PART II</i></b>	<b>ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> <b><i>MANUFACTURER INFORMATION</i></b>
Нэр <i>Name</i>	
Шуудангийн хаяг <i>Postal address</i>	
Утасны дугаар <i>Telephone number</i>	
Факсын дугаар <i>Fax number</i>	
Вэб хаяг <i>Web page</i>	
Харилцах хүн <i>Contact person</i>	
Е-мэйл хаяг <i>E-mail address</i>	
<b>III ХЭСЭГ.</b> <b><i>PART III</i></b>	<b>БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b> <b><i>PRODUCT INFORMATION</i></b>

Эмийн худалдааны нэршил <i>Proprietary name (trade name)</i>			
